



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/202

Алтай хот

Г Хөрөнгө хүлээлцэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 59 дүгээр тогтоолын дагуу 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдагдсан Дарив сумын "Эрчим хүч" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, "Эрдэнэ Эрчим хүч" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын хөрөнгийг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Хаш-Эрдэнэ

Гишүүд:

Б.Золжаргал

Д.Ундрахбаяр

Б.Балдорж

Б.Лхагва-Очир

С.Мянганжадамба

А.Мягмаржав

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлого хариуцсан мэргэжилтэн)

(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

(Эрчим хүчний зохицуулах салбар зөвлөлийн орон тооны гишүүн)

("Дарив-Эрчим хүч" ААТҮГ-ын нягтлан бодогч)

("Эрдэнэ-Эрчим хүч" ААТҮГ-ын захирал)

2.

Б.Нарантуяа ("Эрдэнэ-Эрчим хүч" ААТҮГ-ын
нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын
ахлах мэргэжилтэн)

2. Дуудлагын худалдаагаар худалдсан Дарив сумын "Эрчим хүч" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, Эрдэнэ сумын "Эрчим хүч" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудад хаалтын баланс хийх комиссыг байгуулан, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат), Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Золжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР